



МОНГОЛЫН ЭРС ТЭС  
**УУР**  
**АМЬСГАЛД**  
**ШАЛГАРСАН**

20

ЖИЛИЙН ТУРШЛАГА





# ЕВРОП ЧАНАР – 20 ЖИЛИЙН ИТГЭЛЦЭЛ

Польш улсын Atlas брэндийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч Эс Ти Креатив ХХК нь олон улсын стандартад нийцсэн, Европын чанарын сертификаттай бүтээгдэхүүнийг 20 гаруй жилийн туршлага дээрээ үндэслэн танд санал болгож байна.

## БИД ЮУГААРАА ЯЛГАРДАГ ВЭ?



**ЧАНАРТАЙ**  
БҮТЭЭГДЭХҮҮН



ДИЗАЙНД СУУРИЛСАН  
**СОНГОЛТ**



**МЭРГЭЖЛИЙН**  
ЗӨВЛӨГӨӨ



**ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН**  
ЗӨВЛӨГӨӨ

# БИДНИЙ ДАВУУ ТАЛ

---

## ЕВРОП СТАНДАРТ – ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ШИЛДЭГ ШИЙДЭЛ

Бид зөвхөн барилгын материал нийлүүлэгч бус, таны барилгын насжилт, аюулгүй байдал, гоо зүйн үнэ цэнийг тодорхойлогч технологийн түнш юм.

## ЭКО СОНГОЛТ – VOC 0% ТЕХНОЛОГИ

Бид эрүүл мэндэд ээлтэй бүтээгдэхүүнийг эрхэмлэдэг. Atlas Eco Farba зэрэг дотор ханын материалууд нь химийн хорт ууршилтгүй (VOC 0%) тул хүүхдийн өрөө, эмнэлэг, цэцэрлэг зэрэг өндөр ариун цэвэр шаардсан орчинд хамгийн тохиромжтой сонголт юм.

## ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ – А1 ЗЭРЭГЛЭЛИЙН ХАМГААЛАЛТ

Таны гэр бүлийн аюулгүй байдал бидний тэргүүлэх чиглэл. Манай фасадны материалууд нь олон улсын А1 зэрэглэлийн буюу ҮЛ ШАТАХ ангилалд багтдаг. Энэ нь ил галтай нүүр тулахад шаталтыг дэмжихгүй, хорт утаа ялгаруулахгүй гэсэн баталгаа юм.

## МИКРО АРМАТУРЧЛАЛ – ХАГАРЛЫН ЭСРЭГ ТЕХНОЛОГИ

Манай замаск, шавардлага болон цавууны найрлагад багтсан тусгай микро шилэн эслэгүүд нь гадаргууг температурын эрс өөрчлөлтөд агшиж тэлэх уян хатан чанартай болгодог. Ингэснээр хананд ямар нэгэн ан цав, цууралт үүсэхээс дээд зэргээр сэргийлнэ.

## "АМЬСГАЛДАГ" ХАНА – МӨӨГӨНЦӨРГҮЙ ОРЧИН

Өндөр уур нэвтрүүлэх чадвартай материалууд нь барилгын доторх чийгийг гадагш чөлөөтэй гаргаж, хананд чийг түгжигдэхээс хамгаална. Энэ нь мөөгөнцөр үүсэх нөхцөлийг хааж, эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлдэг.



# БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА



# ATLAS GRAWIS U

ХӨӨСӨНЦӨР ХАВТАН БОЛОН ТОР НААХ ЦАВУУ

## ЗОРИУЛАЛТ:

GRAWIS U цавуу нь хөөсөнцөр хавтан болон бэхэлгээний тор наахад зориулагдсан. Уг цавууг бүх төрлийн бетон, газобетон, цемент болон цемент шохойн шавардалт, тоосго ба блокоор хийгдсэн хуурай гадаргуу, мөн шаазан болон элс, шохойн материалаар хийгдсэн нимгэн үетэй шавардалт ба сайн наалдсан будагтай гадаргууд, барилгын гадна болон дотор талд ашиглана.

## ШИНЖ ЧАНАР:


Дээд зэргийн уян чанартай, уур нэвтрүүлэх чадвартай, ус болон хүйтэнд тэсвэртэй, цементийн найрлагатай, хуурай цавуу юм.

## ЦАВУУГ НАЙРУУЛАХ:

25 кг-аар савлагдсан хуурай цавууг 5-5.5 л усаар, бага w эргэлттэй холигч өрмөөр болон гар аргаар нэг жигд зуурмаг болтол хутгана. Найрлага дахь бодисуудыг бүрэн урвалд ортол 5 минут амраасны дараа ахин хутгаад шууд хэрэглэнэ. Бэлдсэн зуурмагийг ойролцоогоор 3 цаг дотор хэрэглэж дуусгана. Ажлыг хэт халуун, хүчтэй салхи, бороотой үед хийхээс татгалзах хэрэгтэй.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ           |                             |
|-----------------------------------|-----------------------------|
| ХАРЬЦАА:                          | 25кг хольцод, 5,25–5,75л ус |
| ЗАРЦУУЛАЛТ:                       | 4–6м <sup>2</sup>           |
| АШИГЛАХ:                          | Зуурснаас 3 цагийн дотор    |
| ХЭРЭГЛЭХ ОРЧИН БОЛОН СУУРИЙН ХЭМ: | +5-аас +25                  |
| ТЕМПЕРАТУРТ ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ:     | -20, +60                    |
| САВЛАГАА:                         | 25кг                        |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:                 | 12 сар                      |



# ATLAS CETKAN TOP

ДУЛААН ТУСГААРЛАХ СИСТЕМИЙН БЭХЭЛГЭЭНИЙ ТОР

## ЗОРИУЛАЛТ:

Полистирол болон хөвөн хавтанд нь хэрэглэж болох ба цавууны тусламжтайгаар дулаан тусгаарлах системд ашиглагдана.

Дулаан тусгаарлах системийн бүрэлдэхүүн хэсэг - Европын (ЕТА) болон дотоодын (АТ) техникийн зөвшөөрлийг авсан нийлмэл дулаан тусгаарлагч системийн элемент юм.

## ХЭРЭГЛЭХ АРГА:

- Дулаан тусгаарлах хавтанг бэхлэх зориулалттай наалдамхай зуурмагийг зохих ёсоор түрхэж хавтанг байрлуулан тодорхой хугацааны дараа нэмэлт механик бэхэлгээг /хадаас/ хийсний дараа (дунджаар 3 хоногийн дараа) тор татах ажлыг эхлүүлж болно.
- Дулаан тусгаарлах хавтан дээр цавууг жигдхэн тарааж түрхээд торыг босоо чиглэлд /дээрээс доошоо/ байрлуулна.
- Торыг жигд дарж цавууны зузааны хагасаас илүү гүнд оруулах хэрэгтэй /цавууны зузаан 3мм орчим байна/. Өөрөөр хэлбэл тор нь гадаргуутай шууд хүрэлцэхгүй байна гэсэн үг.
- Торыг цавуунд живүүлсэний дараа цавууг гөлгөр төмөр тэгшлэгчээр сайтар татан тэгшилнэ. Торыг 10см өргөн босоо давхцалтайгаар зөрүүлж тасралтгүй явуулна. Торны давхцал нь тусгаарлагч хавтангийн холболттой давхцахгүй байх ёстой.



# ATLAS CERPLAST

ЧУЛУУТ ШАВАРДЛАГЫН СУУРЬ ГРУНТ

## ЗОРИУЛАЛТ:

Cerplast нь акрилын болон минерал төрлийн чулуут шавардлага, гадна өнгөлгөө шавардлагын бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө барилгын суурийг бэхжүүлэхэд ашиглана. Уг бүтээгдэхүүнийг бүх төрлийн сууринд хэрэглэж болно.

## ШИНЖ ЧАНАР:

Cerplast нь цагаан өнгөтэй (бусад өнгөөр гарах боломжтой) ерөнхий зориулалт нь хөрсийг чангаруулж суурийг бэхжүүлэх. Энэ бүтээгдэхүүн нь хэмнэлттэй бөгөөд хэрэглэхэд хялбар. Уг бүтээгдэхүүн нь гадна өнгөлгөөний шаврын цавуулаг хөрсийг бохирдуулахаас давхар хамгаалдаг.

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Cerplast нь шууд хэрэглэх зориулалттай. Уг бүтээгдэхүүнийг өөр бусад материалтай хольж хэт өтгөрүүлэх болон шингэрүүлж болохгүй бөгөөд тагийг онгойлгож жигд сайтар хутгасны дараа хэрэглэнэ.

Бэлдсэн гадаргуу дээр багс болон өнхрүүшээр жигд түрхэнэ. Тухайн гадаргуугийн хэм нь 5°C доош байж болохгүй. Түрхсэнээс хойш 4-6 цагийн дараа гадна өнгөлгөөг хийнэ. Шавардахаас өмнө бүх гадаргуу нь сайтар хатсан байх ёстой.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

|                   |                           |
|-------------------|---------------------------|
| САВЛАГАА:         | 10кг, 25 кг               |
| ЗАРЦУУЛАЛТ:       | 0.3кг нь 1м2 талбайд орно |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА: | 12 сар                    |



# ATLAS CERMIT DR

## ЧУЛУУТ ШАВАРДЛАГА

### ГАДАРГУУГЫН ТӨРӨЛ:

Тоосгон, бетон, керамик, хөндий блок, гипсэн хавтан (дотор), полистирол, XPS бүхий дулаан тусгаарлагч системд ашиглана.

### ГАДАРГУУГ БЭЛДЭХ:

Гадаргуу нь тогтвортой тэгш, бохирдолгүй, хуурай байна. Atlas брэндийн CERPLAST-ийн хамт ашиглавал бат бэх, уян хатан болно.

### ЗУУРМАГ БЭЛТГЭХ:

Хольцыг саванд хийгээд тохирох хэмжээтэй ус /25кг-д 5.5-6.5л ус/ хийн гараар болон зөөлөн эргэлттэй дриллээр хутган нэгэн жигд зуурмаг болгоно. Найрлаган дахь бодисуудыг бүрэн урвалд ортол 10 минут амраасны дараа ахин сайтар хутгаад шууд хэрэглэнэ. 1-1.5 цагийн дотор хэрэглэнэ.

### ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ                       |                                                        |
|-----------------------------------------------|--------------------------------------------------------|
| ЗУУРМАГ БЭЛТГЭХ<br>УСНЫ ХАРЬЦАА:              | 5.5-6.5 л ус                                           |
| ЗАРЦУУЛАЛТ:                                   | 6.5-7м2                                                |
| САВЛАГАА:                                     | 25кг                                                   |
| АЖИЛЛАХ ОРЧНЫ<br>БОЛОН СУУРИЙН<br>ТЕМПЕРАТУР: | +5 аас +25                                             |
| ЗУУРМАГИЙГ<br>АМРААХ ХУГАЦАА:                 | 10 минут                                               |
| ХЭРЭГЛЭХ:                                     | Зуурмаг бэлэн болсноос<br>хойш 1-1.5 цаг               |
| ХАТАХ ХУГАЦАА:                                | 12-48 цаг /агаарын чийгшил,<br>температураас хамаарна/ |



# ATLAS UNI-GRUNT

СУУРЬ БЭХЖҮҮЛЭГЧ ГРУНТ  
/ГАДНА БОЛОН ДОТОРХЭРЭГЛЭХ БОЛОМЖТОЙ/

## ЗОРИУЛАЛТ:

Uni-Grunt нь эмульс болон шал тэгшлэгч, ханын цаас, ус тусгаарлагч гэх мэт суурийг бэхжүүлэх зорилгоор ашиглана.

## ШИНЖ ЧАНАР:

Нэгдмэл болгож барьцалдуулан суурийг бэхжүүлдэг. Шалны доор, шавардлагын гадаргуу, цавуу, гипс, өнгөлгөө, зэрэгт ашиглаж болно.

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

ATLAS UNI-GRUNT нь ашиглахад бэлэн хэлбэрээр үйлдвэрлэгддэг. Харин жингийн харьцаагаар шингэлэхийг зөвшөөрнө. Уг бүтээгдэхүүнийг нимгэн, жигд байдлаар өнхрүүш эсвэл багс ашиглан нэг удаа шингэлээгүй хэлбэрээр гадаргуу дээр түрхэнэ. Их шингээлттэй суурь болон сул суурийн эхний хөрсжүүлэлтийг цэвэр усаар 1:1-ийн харьцаагаар шингэрүүлсэн грунтыг хэрэглэж болно. Эхний үе хатсаны дараа бэхжүүлэлтийг дахин шингэрүүлээгүй грунтыг ашиглан хийнэ. Гадаргууг эмульс түрхсэний дараа 24 цагийн дараа ашиглаж болно.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

|                      |                                                                             |
|----------------------|-----------------------------------------------------------------------------|
| НЭМЭЛТ ДАВХАРГА:     | 2-6 цагийн дараа /орчны температураас хамаарна/                             |
| ЗАРЦУУЛАЛТ:          | 25-100м2, 0.05 - 0.2 кг /1 м² / практикт гадаргуугийн шингээлтээс хамаарна/ |
| САВЛАГАА:            | 5кг                                                                         |
| ХЭРЭГЛЭХ ТЕМПЕРАТУР: | +5 аас +30                                                                  |
| ТЭСВЭР:              | Бүрэн хатсанаас хойш -20, +80 градус                                        |
| ЭМУЛЬСИЙН ӨТГӨРӨЛТ:  | 1.0г/см3                                                                    |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:    | 12 сар                                                                      |
| ХАТАХ ХУГАЦАА:       | Ажил хийгдсэнээс хойш 24 цаг                                                |



# ATLAS ECO FARBA

ЭМУЛЬС  
/ЦАГААН ӨНГӨТЭЙ/

## ЗОРИУЛАЛТ:

Акрилын будаг ATLAS ECO FARBA нь дотор гадаргууг будахад зориулагдсан бөгөөд анхдагч эсвэл сэргээх, өнгө үзэмж сайжруулах зорилгоор ашиглаж болно.

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Хэрэглэхийн өмнө будгийг сайтар сэгсэрч хутган нэгэн жигд болгоно. Будагдаа өнхрүүш, багс, шүршигч зэргийг ашиглаж болно. Ээлжит давхаргаа түрхэхдээ өмнөх давхарга бүрэн хатсаны дараа нэмэх тэмдгийн аргаар хийж гүйцэтгэнэ. 1л будгаар 14м<sup>2</sup> талбайг будна.

Зарцуулалт нь суурийн шингээлтээс хамаарна. Давхарлах тохиолдолд эхний давхаргыг 10л эмульсыг 0.5л усаар шингэрүүлж болно. Харин сүүлийн давхаргыг шингэрүүлээгүй эмульсээр будна. Будаг хатах хугацаа нь сууриас, агаарын хэт болон харьцангуй чийгшлээс хамааран ойролцоогоор 2-6 цаг байна.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ |                                        |
|-------------------------|----------------------------------------|
| ЗАРЦУУЛАЛТ:             | 50-140м <sup>2</sup>                   |
| САВЛАГАА:               | 10л                                    |
| ОРЧИН БОЛОН СУУРЫН ХЭМ: | +5 аас +25                             |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:       | 24 сар                                 |
| ХАТАХ ХУГАЦАА:          | 2-6 цаг /орчны температураас хамаарна/ |



# ATLAS ACRYLIC RENDER

ЧУЛУУТАЙ ШАВАРДЛАГА

## ШИНЖ ЧАНАР:

- Ус, чийгт тэсвэртэй
- Амархан бохирдохгүй
- Суурьтай маш сайн барьцалдаж өгдөг
- Үндсэн өнгө цагаан
- Механик гэмтэлд тэсвэртэй байдал улам сайжирсан
- Байгальд ээлтэй, хүний биед сөрөг нөлөөгүй
- 400 өнгөний сонголтоос кодоор гарах боломжтой

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Хэрэглэхийн өмнө гараар эсвэл зөөлөн эргэлттэй холигчоор нэгэн жигд болтол сайтар хутгана. Бэлтгэсэн гадаргуу дээрээ ниви ашиглан нэгэн жигд хөнгөн дарж түрхэнэ.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

|                         |                                                           |
|-------------------------|-----------------------------------------------------------|
| ЗАРЦУУЛАЛТ:             | 6.5-7м2                                                   |
| САВЛАГАА:               | 25кг                                                      |
| ОРЧИН БОЛОН СУУРЫН ХЭМ: | +5 аас +25                                                |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:       | 12 сар                                                    |
| ХАТАХ ХУГАЦАА:          | 12-48 цаг /агаарын чийгшил, орчны температураас хамаарна/ |
| АШИГЛАХ:                | Савыг онгойлгосноос 1.5 цагийн дотор                      |

# ATLAS SALTA E

Е-ФАСАДНЫ АКРИЛ БУДАГ

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

### ГАДАРГУУГ БЭЛТГЭХ:

Түрхэх суурь нь бат бөх, будагны тогтцод нөлөөлөх хуурай, тоос шороогүй, жигд байна.

Бага зэргийн гэмтлийг (хагарал, суурьны хоосон зайг) засч, дахин нөхөж өнгөлсөн байна. Өндөр шингээлттэй суурь болон бусад шингээлт өндөр гадаргууг ATLAS UNI-GRUNT-ыг ашиглавал тохиромжтой.

### БУДАГ БЭЛДЭХ:

Хэрэглэхийн өмнө бага хурдтай нэмэлт хошуутай өрмийн тусламжтай сайтар хольж хутгана.

- МАШ САЙН ТОГТОЦТОЙ ӨНГӨ
- ТҮРХЭЛТ БОЛОН ТАРХАЛТ ӨНДӨР
- УС ЧИЙГИЙН ӨНДӨР ХАМГААЛАЛТТАЙ
- ӨӨРИЙГӨӨ ЦЭВЭРЛЭХ ДАВУУ ТАЛТАЙ



## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ                          |                              |
|--------------------------------------------------|------------------------------|
| НЯГТАРШИЛ:                                       | ≈1,52 кг/дм <sup>3</sup>     |
| ЦАВУУЛАГИЙН ТҮВШИН:<br>(PN-80/C-81531-ИЙН ДАГУУ) | 1                            |
| SD                                               | 0,14-1,4 м                   |
| АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ОРЧНЫ ТЕМПЕРАТУР:                 | +5°C хэмээс +25°C хэм хүртэл |
| ДАРААГИЙН ДАВХАРГА ТҮРХЭХ ХУГАЦАА:               | ≈6 цаг                       |
| ХАТАХ ХУГАЦАА:                                   | 2-4 цаг                      |

| ЗАРЦУУЛАЛТ                                                                 |                                |                         |
|----------------------------------------------------------------------------|--------------------------------|-------------------------|
| ӨНГӨЛСӨН ГАДАРГУУНЫ ТӨРӨЛ                                                  | 1 М <sup>2</sup> -Н ЗАРЦУУЛАЛТ | 1 Л БУДГИЙН ЗАРЦУУЛАЛТ  |
| МИНЕРАЛИЙН ТӨРЛИЙН CERMIT SN, DR, MN, SN-MAL, ND И ND-P БЭЛТГЭСЭН ГАДАРГУУ | 0,25 Л                         | ≈4,0 М <sup>2</sup>     |
| ДИСПЕРСИЙН ТӨРЛИЙН CERMIT N, SILKON N, SAN ӨНГӨЛГӨӨ                        | 0,20 Л                         | ≈5,0 М <sup>2</sup>     |
| УЛАМЖЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮН ATLAS, ATLAS REKORD SZARY ӨНГӨЛГӨӨНИЙ ЗУУРМАГ       | 0,15 Л                         | ≈6,0-7,0 М <sup>2</sup> |

# ATLAS GRAWIS DUO



ХӨӨСӨНЦӨР БОЛОН ЧУЛУУН ХӨВӨН  
ХАВТАН НААХ, ТОР НААХ УНИВЕРСАЛ ЦАВУУ  
/3D ТАЛСТ БЭХЖҮҮЛЭЛТТЭЙ/

## ЗОРИУЛАЛТ:

GRAWIS DUO нь хөөсөнцөр хавтан (EPS, 50 см хүртэлх зузаантай), чулуун хөвөн (базальт хөвөн, 30 см хүртэлх зузаантай) хавтанг барилгын гадна фасадад наах, мөн бэхжүүлэх (тор наах) давхарга үүсгэхэд зориулсан универсал хуурай хольцот цавуу юм. Ихэвчлэн галын аюулгүй байдлын шаардлагаар нэг ханан дээр хоёр өөр төрлийн дулаалгын материал (жишээ нь доод давхаргад чулуун хөвөн, дээд хэсэгт хөөсөнцөр)-ыг хослуулан ашиглах үед материалын залгаас дээр ан цав үүсэхээс сэргийлдэг 3D утаслаг бэхжүүлэлттэй тул тохиромжтой шийдэл юм.

## ШИНЖ ЧАНАР:

- Гурван хэмжээст (3D) утаслаг бэхжүүлэлттэй тул ан цав үүсэхээс сэргийлж, механик ачаалал, цохилтод тэсвэртэй.
- Нэг цавуугаар хавтан наах, тор наах хоёр үйлдлийг гүйцэтгэдэг (2-in-1 шийдэл).
- Наасны дараа 24 цагийн дотор (+20°C-д) багаж ашиглан механик бэхэлгээ хийх түвшинд бэхждэг.
- Бетон, тоосго, минералын шавардлага, силикат, блок зэрэг олон төрлийн (шинэ болон хуучин) гадаргуу дээр ашиглах боломжтой.
- EPS, XPS, чулуун хөвөнтэй хамт ашиглагддаг универсал бүтээгдэхүүн.

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Хольцыг 25 кг-д 5.25–5.75 л (буюу 1 кг-д 0.21–0.23 л) цэвэр усаар зуурч, 5 минут амраасны дараа дахин сайтар хутгаж бэлэн болгоно. Бэлдсэн хольцыг 15 минутын дотор гадаргуу дээр түрхэж эхлэнэ. 2.5 цагийн дотор бүрэн хэрэглэж дуусгана. Хавтан наахад периметр болон цэгэн аргаар (голдоо 3–4 цэг, ирмэгээр тасралтгүй зурвас) түрхэнэ. Тор наахад гадаргуу дээр бүрэн бүрхэх байдлаар 2–5 мм (хөөсөнцөр) эсвэл 4–6 мм (чулуун хөвөн) зузаантай тэгш давхарга үүсгэж түрхээд, торыг дардаг аргаар живүүлнэ. Орчны болон гадаргуугийн температур +3°C-аас +30°C хооронд байх ёстой.

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| ҮЗҮҮЛЭЛТ                                                                                    | ЗААЛТ / УТГА                                                                |
|---------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|
| САВЛАГАА:                                                                                   | 25кг                                                                        |
| ХОЛЬЦЫН ХАРЬЦАА:<br>(УС)                                                                    | 5.25–5.75л / 25 кг<br>(0.21–0.23л/кг)                                       |
| АЖИЛЛАХ ОРЧНЫ<br>ТЕМПЕРАТУР:                                                                | +3°C -аас +30°C                                                             |
| ХОЛЬЦ АМРАХ<br>ХУГАЦАА:                                                                     | ~5 минут                                                                    |
| ХЭРЭГЛЭХ<br>БОЛОМЖТОЙ<br>ХУГАЦАА:<br>(OPEN TIME)                                            | ≥15 минут                                                                   |
| ХАТАХ ХУГАЦАА:                                                                              | 2–4 цаг                                                                     |
| БҮРЭН АШИГЛАХ<br>БОЛОМЖТОЙ<br>ХУГАЦАА:                                                      | ~2.5 цаг                                                                    |
| ЗАРЦУУЛАЛТ<br>ХАВТАН НААХ<br>• EPS<br>• ЧУЛУУН ХӨВӨН<br>ТОР НААХ<br>• EPS<br>• ЧУЛУУН ХӨВӨН | 4.0–5.0кг/м²<br>4.5–5.5кг/м²<br><br>3.0–3.5кг/м²<br>4.0–6.0кг/м²            |
| ДАВХАРГЫН ЗУЗААН<br>• EPS<br>• ЧУЛУУН ХӨВӨН                                                 | 2–5 мм<br>4–6 мм                                                            |
| ДЮБЕЛЬ АШИГЛАХ<br>БОЛОМЖТОЙ<br>ХУГАЦАА:                                                     | 24 цаг (+20°C-д)                                                            |
| ТОХИРОХ<br>ДУЛААЛГЫН<br>МАТЕРИАЛЫН<br>ЗУЗААН:                                               | EPS ≤50см<br>Чулуун хөвөн ≤30 см                                            |
| ТОХИРОХ СУУРЬ<br>ГАДАРГУУ:                                                                  | Бетон, тоосго, минералын<br>шавардлага, силикат блок<br>(шинэ болон хуучин) |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:                                                                           | 12 сар (хуурай орчинд, лац бүрэн)                                           |

# ЧУЛУУН ХӨВӨН ХАВТАН /140 КГ/М³/

ФАСАДНЫ ДУЛААЛГЫН СИСТЕМД ЗОРИУЛСАН ӨНДӨР НЯГТРАЛТАЙ  
БАЗАЛЫТ ХӨВӨН ХАВТАН

### ЗОРИУЛАЛТ:

Чулуун хөвөн (базальт хөвөн) хавтан нь барилгын гадна фасадын дулаалгын систем (ETICS)-д зориулагдсан, гал тэсвэрлэлт өндөртэй, дулаан тусгаарлах чадвар сайтай материал юм. Шавардлага, тор, өнгөлгөөний ачааллыг сайн даах чадвартай бөгөөд механик ачаалал ихтэй, шаардлага өндөртэй фасадын хананд (олон давхар байшин, нийтийн барилга, дэд станц, галын хана гэх мэт) хэрэглэхэд тохиромжтой.



### ШИНЖ ЧАНАР:

- A1 ангиллын шатамхай бус, гал бүрэн тэсвэртэй материал
- Дулаан дамжуулах чанар бага, дулаалгын чадвар өндөр
- Ус үл нэвтрүүлэх (гидрофобжуулсан), уур сайн нэвтрүүлдэг тул хана "амьсгалдаг"
- Дуу шингээх өндөр чадвартай
- Хэмжээ хэлбэрээ тогтвортой хадгалдаг, цаг уурын хүчин зүйлд тэсвэртэй
- Механик гэмтэлд тэсвэртэй, өндөр татах бат бэхтэй

### ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Хавтанг гадаргуу дээр цавуугаар периметр болон цэгэн байдлаар (голдоо) наана, наалдацыг сайжруулахын тулд гадаргуу тэгш, тоос, шороо цэвэрлэгдсэн байх ёстой. Хавтангуудыг зөрүүлж, "тоосго шиг" зэрэгцүүлэн байрлуулна. Наасны дараа механик бэхэлгээ (дюбель)-ээр нэмэлт бэхэлнэ (м² тутамд дундажаар 6–8 ширхэг). Бүрэн хатсаны (ойролцоогоор 2–3 хоног) дараа гадаргуу дээр тор наах, шавардлага хийх ажлыг үргэлжлүүлнэ.

### ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| ҮЗҮҮЛЭЛТ                                           | ЗААЛТ / УТГА                                     |
|----------------------------------------------------|--------------------------------------------------|
| НЯГТРАЛ:                                           | 140 кг/м³                                        |
| ТАТАХ БАТ БЭХ TR15:<br>(ГАДАРГУУТАЙ ПЕРПЕНДИКУЛЯР) | ≥15 кПа                                          |
| ДУЛААН ДАМЖУУЛАХ КОЭФФИЦИЕНТ λD:                   | ≤0.040 Вт/(м·К)                                  |
| ШАХАЛТЫН ЭСЭРГҮҮЦЭЛ:<br>(10% ХЭВ ГАЖИЛТАЙ ҮЕД)     | ≥40 кПа                                          |
| ГАЛ ХАМГААЛАЛТЫН АНГИЛАЛ:<br>(EN 13501-1)          | A1 (Шатамхай бус)                                |
| УС ШИНГЭЭЛТ:<br>(БОГИНО ХУГАЦААНЫ, 24 ЦАГ)         | ≤1.0 кг/м²                                       |
| УС ҮЛ НЭВТРҮҮЛЭХ ЧАНАР:<br>(ГИДРОФОБЖИЛТ)          | ≥99%                                             |
| УУРЫН ЭСЭРГҮҮЦЛИЙН КОЭФФИЦИЕНТ:<br>(μU)            | ≈1                                               |
| СТАНДАРТ ХЭМЖЭЭ:<br>(ӨРГӨН Х УРТ)                  | 600x1000 / 1200 мм                               |
| ЗУЗААН:                                            | 150мм                                            |
| СТАНДАРТ:                                          | EN 13162, MW-EN13162-T5-WS-WL (P)-MU1-AF100-TR15 |

# ДОТОР ХАНЫН ЦАГААН ЭМУЛЬС БУДАГ

УСАН СУУРЬТАЙ АКРИЛ ЭМУЛЬС, ДОТОР ОРЧИНД  
ЗОРИУЛАГДСАН



## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| ҮЗҮҮЛЭЛТ                                 | ЗААЛТ / УТГА                                 |
|------------------------------------------|----------------------------------------------|
| САВЛАГАА:                                | 18Л                                          |
| ТЕКСТУР:<br>(FINISH)                     | Матт                                         |
| ӨНГӨ:                                    | Цагаан                                       |
| ЗАРЦУУЛАЛТ:<br>(ДАВХАРГА ТУТАМД)         | 0.1-0.3м²/kg                                 |
| ХАТАХ ХУГАЦАА:<br>(ХҮРЭХ)                | 1-2 цаг                                      |
| ДАРААГИЙН<br>ДАВХАРГА ТҮРХЭХ<br>ХУГАЦАА: | 3-5 цаг                                      |
| БҮРЭН ХАТАХ<br>ХУГАЦАА:                  | 12 цаг                                       |
| VOC АГУУЛАМЖ:                            | <50г/л (бага хорт ууршилттай)                |
| ХАДГАЛАХ ХУГАЦАА:                        | 24 сар (задлаагүй үед)                       |
| ХАДГАЛАХ<br>ТЕМПЕРАТУР:                  | 5°C-35°C /Нарны шууд<br>тусгалаас хол газар/ |

## ЗОРИУЛАЛТ:

Дотор ханын цагаан эмульс будаг нь орон сууц, оффис, олон нийтийн барилгын дотор ханын гадаргуу (гөлгөр шавардлага, гипс хавтан, бетон гэх мэт)-г будахад зориулагдсан усан суурьтай акрилын будаг юм. Анхдагч болон сэргээн засварлах будалтад, мөн өнгө, үзэмжийг сайжруулах зорилгоор ашиглана.

## ШИНЖ ЧАНАР:

- Цэвэр цагаан өнгөтэй, өндөр хучих чанартай
- Матт, гадаргуу жигд
- VOC-ийн агууламж бага, үнэр ялгаруулалт бага
- Хурдан хатдаг, наалдац сайтай
- Даралт, чийгт тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар
- Цайрахгүй, хагарахгүй уян хатан бүрхэвч үүсгэдэг

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

Гадаргуу жигд, цэвэр, хуурай байлгах ба суурь грунт түрхэж бэлтгэсэн байна. Будгийг сайтар хутгаж, эхний давхаргад цэвэр усаар 10-20% хүртэл шингэлж болно (сүүлийн давхаргад бага буюу шингэлэхгүй хэрэглэнэ). Өнхрүүш эсвэл шүршигчээр 2 давхар түрхэнэ, давхаргын хооронд бүрэн хатаах (2-4 цаг) шаардлагатай.

# ДУЛААН ТУСГААРЛАХ ХАВТАНГИЙН ХАДААСАН БЭХЭЛГЭЭ

- ТӨМӨР ГОЛТОЙ /6ММ/, PVC ХАДААС /10ММ/
- ЦАНТАЛТААС ХАМГААЛСАН PVC МАЛГАЙТАЙ
- БЛОК, БЕТОН, ТООСГОН ХАНАНД БЭХЛЭНЭ
- EPS, XPS ХӨӨСӨНЦӨР ТОГТООНО

## ЗОРИУЛАЛТ:

1 м<sup>2</sup> тутамд бэхэлгээний тоо 4 ширхэгээс багагүй байна. Барилгын булангийн бүсэд бэхэлгээний тоог нэмэгдүүлэх хэрэгтэй.

## ҮНДСЭН ХЭМЖЭЭ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ |                                |
|-------------------------|--------------------------------|
| ДИАМЕТР:                | 10мм                           |
| УРТ:                    | 90-220мм /хуванцар голтой/     |
| УРТ:                    | 220, 260, 300мм /төмөр голтой/ |



## АНХААРУУЛГА:

Төмөр голтой хадаасыг бетон он хананд 2мм-ээр том нүхэлж ашиглана.

# БУЛАНТОР

## УСНЫ ХАЯЛГАТАЙ

- Усны хаялгатай булан торыг хаалга болон цонхны дээр тавьж өгснөөр буланг дагаж ус урсахаас сэргийлж, фасадны насжилтыг нэмнэ.
- Фасадны булан, ирмэгийг хамгаалах
- Хэрэглэхэд хялбар
- Өнгөлгөөний өмнө хурц, шулуун өнцөг гаргаж өгнө
- Механик гэмтлээс сэргийлнэ
- Урт: 2.5 м



# ATLAS CERMIT ND

N ТӨРЛИЙН МИНЕРАЛ СУУРЬТАЙ ЧУЛУУТ ШАВАРДЛАГА

## ГАДАРГУУГИЙН ТӨРӨЛ:


Тоосгон, бетон, керамик, хөндий блок, гипсэн хавтан (дотор), полистирол, хрс бүхий дулаан тусгаарлагч системд ашиглана.

## ГАДАРГУУГ БЭЛТГЭХ:

Гадаргуу нь тогтвортой тэгш, бохирдолгүй, хуурай байна. Atlas брэндийн CERPLAST-ийн хамт ашиглавал бат бэх, уян хатан болно.

## ЗУУРМАГ БЭЛТГЭХ:

Хольцыг саванд хийгээд тохирох хэмжээтэй ус /25кг-д 5.5-6.5л ус/ хийн гараар болон зөөлөн эргэлттэй дриллээр хутган нэгэн жигд зуурмаг болгоно. Найрлаган дахь бодисуудыг бүрэн урвалд ортол 10 минут амраасны дараа ахин сайтар хутгаад 1-1.5 цагийн дотор хэрэглэнэ.



# ATLAS GEOFLEX

## 120X120 CM ХҮРТЭЛХ ПЛИТАНЫ ЦАВУУ C2TE

ATLAS GEOFLEX нь силика гель нэмэлт бодис агуулсан тул бүх төрлийн гадаргуу дээр жигд тархаж усыг сайн шингээн, илүү наалдамхай бүтцийг үүсгэдэг. 120x120 см хүртэлх керамик плита, грес, мозайк, чулуу болон наахад хүндрэлтэй гадаргуу болох хуучин плита, OSB, балкон, цементэн гадаргуу дээр наах боломжтой.

### ЦАВУУГ БЭЛТГЭХ:

1. Цавууг бэлтгэхдээ цэвэрхэн сав болон багаж хэрэглэнэ.
2. Цавууг (5°C-аас 25°C хүртэлх) хэмийн усанд хэмжээний дагуу зуурна. (хуурай хольцыг усруу бага багаар хийнэ) 25 кг хольцыг – 6.5 литр (хана), 8.25 литр (шал) усаар зуурна.
3. Тухайн бүтээгдэхүүний шинж чанар зөвхөн заавар дарааллын дагуу чанд дагаж мөрдөж усаар зуурахыг анхаарна уу.
4. Цавуугаа сайтар зуурч хутгана. (хольцыг тусгай миксер ашиглаж зуурах эсвэл өрмийн хошуунд тусгай нэмэлт зуурагч хошуу хийж зуурах ба өрмийн эргэлтийн хурд нь минутад 400–800 байна).
5. Бүх химийн урвал явагдаж дуустал 5 минут хүлээнэ.
6. Дахин хутгаад шууд хэрэглэнэ.

| ПЛИТАНЫ УРТ                           | 120X120 CM |     |
|---------------------------------------|------------|-----|
| ГАДАРГУУНЫ ТӨРӨЛ                      | ХАНА       | ШАЛ |
| <b>ШААЗАН ХАВТАН</b>                  | +          | +   |
| ТЕРРАКОТТА                            | +          | +   |
| БҮРХҮҮЛТЭЙ ХАВТАН                     | +          | +   |
| КЕРАМИК МОЗАЙК                        | +          | +   |
| СУУРИЙН ТӨРӨЛ                         | +          | +   |
| ПЛИТА                                 | +          | +   |
| ЦЕМЕНТ БА ЦЕМЕНТ ШОХОЙН ГИПС          | +          | +   |
| ТООСГО ЭСВЭЛ СИЛИКАТ БЛОК ХАНА        | +          | +   |
| АЖИЛЛАХ ХҮРЭЭ                         | +          | +   |
| ХЭВИЙН ЧИЙГШИЛТЭЙ ӨРӨӨ                | +          | +   |
| ӨНДӨР ЧИЙГШИЛТЭЙ ӨРӨӨ (УГААЛГЫН ӨРӨӨ) | +          | +   |
| ГАДНАХ АЖЛУУД (ФАСАД, ЦОКОЛЬ, БАЛКОН) | +          | +   |



### ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

| БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ |                                      |
|-------------------------|--------------------------------------|
| УСНЫ ХАРЬЦАА:           | 6.5–8.25 л / 25 кг                   |
| ЗУЗААН MIN/MAX:         | 2 мм / 15 мм                         |
| САВЛАГАА:               | 25 кг                                |
| ЗАРЦУУЛАЛТ:             | 8 м²                                 |
| ХАТАХ ХУГАЦАА:          | 12 цаг                               |
| АШИГЛАХ:                | Савыг онгойлгосноос 1.5 цагийн дотор |

# ATLAS ULTRA GEOFLEX

300×300 CM ХҮРТЭЛХ БУЮУ ТОМ ХЭМЖЭЭТЭЙ ПЛИТАНЫ ЦАВУУ C2TE S1

ATLAS ULTRA GEOFLEX нь GEOFLEX-ийн бүх шинжийг агуулсан бөгөөд нэмэлт бодис хийж өгснөөр илүү MEGA хэмжээтэй хавтанг усан, фасад, балкон, террас, хуучин плита болон наахад хүндрэлтэй гадаргуу дээр ашиглахад тохиромжтой болгож өгсөн.

S1-том хавтан дээр ирдэг гадны ачаалалд илүү уян хатан байж ачааллыг жигд тарааж өгнө.

## ЦАВУУГ БЭЛТГЭХ:

1. Цавууг бэлтгэхдээ цэвэрхэн сав болон багаж хэрэглэнэ.
2. Цавууг (5°C-аас 25°C хүртэлх) хэмийн усанд хэмжээний дагуу зуурна (хуурай хольцыг ус руу бага багаар хийнэ). 25 кг хольцыг 6.5 литр (хана), 8.25 литр (шал) усаар зуурна.
3. **Анхаар!** Тухайн бүтээгдэхүүний шинж чанар зөвхөн заавар дарааллын дагуу чанд дагаж мөрдөж усаар зуурна.
4. Цавуугаа сайтар зуурч хутгана. (Хольцыг тусгай миксер ашиглаж зуурах эсвэл өрмийн хошуунд тусгай нэмэлт зуурагч хошуу хийж зуурах ба өрмийн эргэлтийн хурд нь минутанд 400–800 байна.)
5. Бусад бүтээгдэхүүн шиг амраана.
6. Дахин хутгаад шууд хэрэглэнэ.



## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

|                 |                                         |
|-----------------|-----------------------------------------|
| УСНЫ ХАРЬЦАА:   | 6.5–8.25 л / 25 кг                      |
| ЗУЗААН MIN/MAX: | 2 мм / 15 мм                            |
| САВЛАГАА:       | 25 кг                                   |
| ЗАРЦУУЛАЛТ:     | 8 м²                                    |
| ХАТАХ ХУГАЦАА:  | 12 цаг                                  |
| АШИГЛАХ:        | Савыг онгойлгосноос<br>1.5 цагийн дотор |

### ПЛИТАНЫ УРТ

120X120 CM

| ГАДАРГУУНЫ ТӨРӨЛ                      | ХАНА | ШАЛ |
|---------------------------------------|------|-----|
| ШААЗАН ХАВТАН                         | +    | +   |
| ТЕРРАКОТТА                            | +    | +   |
| БҮРХҮҮЛТЭЙ ХАВТАН                     | +    | +   |
| КЕРАМИК МОЗАЙК                        | +    | +   |
| СУУРИЙН ТӨРӨЛ                         | +    | +   |
| ПЛИТА                                 | +    | +   |
| ЦЕМЕНТ БА ЦЕМЕНТ ШОХОЙН ГИПС          | +    | +   |
| ТООСГО ЭСВЭЛ СИЛИКАТ БЛОКХАНА         | +    | +   |
| АЖИЛЛАХ ХҮРЭЭ                         | +    | +   |
| ХЭВИЙН ЧИЙГШИЛТЭЙ ӨРӨӨ                | +    | +   |
| ӨНДӨР ЧИЙГШИЛТЭЙ ӨРӨӨ (УГААЛГЫН ӨРӨӨ) | +    | +   |
| ГАДНАХ АЖЛУУД (ФАСАД, ЦОКОЛЬ, БАЛКОН) | +    | +   |

# ATLAS M-SYSTEM 3G

ГИПС ХАВТАН, OSB, ФИБРО-ЦЕМЕНТ ХАВТАН  
БЭХЛЭХ ТОХИРУУЛГАТАЙ ХОЛБОГЧ СИСТЕМ

## ЗОРИУЛАЛТ:

Atlas M-System 3G нь гипс, фибро-цемент, OSB хавтанг хана, тааз, дээврийн дор налуу хэсэг болон шаланд угсрахад зориулсан тохируулгатай бэхлэгээний холбогч систем юм. Модон эсвэл металл каркасгүйгээр шууд хананд бэхлэх боломжтой тул дүнзэн таазан доогуур дулаан, дуу тусгаарлагч материал байрлуулах, агааржуулалт болон инженерийн шугам сүлжээг таазан дээр далдлах зэрэгт өргөн ашиглагдана. Шинэ барилга болон засварын ажилд аль алинд нь тохиромжтой.

## ХЭРЭГЛЭХ ЗААВАР:

1. Хана, тааз эсвэл шалан дээр өрөмдлөг хийж, тэлэгчийг (полипропилен өргөтгөх дюбел) байрлуулна.
2. Ган холбогч (тавцантай ширхэг)-ийг тэлэгчинд эргүүлэн оруулж, шаардлагатай зайг тохируулна (шаардлагатай бол өнцгийн хазайлтыг мөн тохируулна).
3. Тавцан дээр гипс хавтан, OSB, фибро-цемент зэрэг хавтанг иж бүрдэлд орсон хавтан бэхлэх шургаар бэхэлнэ.

## ШИНЖ ЧАНАР:

- Хана/тааз болон хавтангийн хоорондох зайг 1 см-ээс эхлэн шат ахиулан тохируулах боломжтой
- 27° хүртэл өнцгийн хазайлтыг засах боломжтой тул гадаргуу тэгш бус, ташуу, муруй байсан ч хялбар суурилуулна
- Гадаргууг урьдчилан тэгшлэх, шороо арчих, грунтлах зэрэг бэлтгэл ажил шаардахгүй
- Механик ачаалал даах, бат бөх чанартай, дахин ашиглах, задлах боломжтой
- Эд ангиуд нь зэвэрдэггүй, удаан эдэлгээтэй

## ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ:


| ҮЗҮҮЛЭЛТ                        | ЗААЛТ / УТГА                                                                                                        |
|---------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|
| АШИГЛАХ ХЭСЭГ:                  | Хана, тааз, дээврийн налуу хэсэг, шал                                                                               |
| УРТ<br>(ХАНА/ТААЗ/НАЛУУ ЗАГВАР) | L250 мм                                                                                                             |
| ӨНЦГИЙН ТОХИРУУЛГА:             | 27°                                                                                                                 |
| ТАВЦАНГИЙН МАТЕРИАЛ:            | Полипропилен<br>(М8 дотоод мушгиатай, цайрдсан хайлш бөмбөлөгт үетэй)                                               |
| ХОЛБОГЧ ШИРХЭГИЙН МАТЕРИАЛ:     | Ган                                                                                                                 |
| ДЮБЕЛИЙН МАТЕРИАЛ:              | Полипропилен                                                                                                        |
| ТОХИРОХ ХАВТАНГИЙН ЗУЗААН:      | 09-28 мм<br>(стандарт ГКХ/OSB, загвараас хамаарна)                                                                  |
| АЧААЛЛЫН ДААЦ:<br>(НЭГ ШИРХЭГТ) | ~100 кг хүртэл                                                                                                      |
| ИЖ БҮРДЭЛ:<br>(1 БАГЦ)          | 21 дюбель + 21 холбогч + 21 тавцан + 84 хавтан бэхлэх шурга + суурилуулах заавар                                    |
| ГЭРЧИЛГЭЭ/ СТАНДАРТ:            | Польшийн Krajowa Ocena Techniczna (үндэсний техникийн үнэлгээ), ZKP тохирлын гэрчилгээ, Гүйцэтгэлийн мэдэгдэл (DoP) |
| ҮЙЛДВЭРЛЭГЧ:                    | ATLAS Sp. z o.o.<br>(Польш)                                                                                         |



# ХЭРЭГЛЭХ ЗААВАР:




Суурийг хэмжиж, хавтангуудын байрлалыг төлөвлөнө, хамгийн багадаа 20см хавтан суурилуулж болох ба дараа нь хавтангийн залгаа орох хэсгийг тэмдэглэнэ



Гипсэн хавтангийн хамгийн жижиг нөхөх хэсгийг 4 цэгт (4 бэхэлгээний тавган дээр) тулгуурлан бэхлэх шаардлагатай. Жишээг дээрх зурагт үзүүлэв.



Тохирах бэхэлгээ хоорондын зайг сонгож нүх гаргах цэгүүдийг тэмдэглэнэ.



Цэгүүдийг тодорхойлсны дараа ханын эргэн тойронд ирмэг бүрээс 7 см-ийн зайд бэхэлгээний гадна талын эгнээг тэмдэглэнэ. **АНХААР:** 7 см нь сонгосон зөвшөөрөгдөх хоорондын зайд багтсан байх ёстой.



Тэмдэглэсэн цэгүүдэд нүх өрөмдөнө.



Бетон суурь: өрөмдсөн нүхэнд тулгуур тэлэгч суулгана.

Модон суурь: бэхэлгээний шрупыг өрөмдсөн нүх рүү тэлэгч ашиглалгүйгээр шууд суулгана.



Лазерын тусгалыг хавтан тогтоох хэмжээнд тохируулан тааруулж тавьна (ханын тэгш бус байдал болон гипсэн хавтангийн зузааныг тооцоорой). Дрил дээр зурагт үзүүлсэн байдлаар тэмдэглэгээ тавих ба лазерын тусгал, хавтангийн тэмдэглэгээ давхцах үед дрилдхээ зогсоно. Ингэснээр хавтангийн тэгш хэмийг хангаж чадна.




Бүх бэхэлгээг лазерын шугамын дагуу тогтооно.




Бэхэлгээний хавтгайн түвшинг хэмжигчээр шалгана.



Хавтанг тогтоохдоо эхний бэхэлгээг гараараа барьж байгаад тогтооно.




Бэхэлгээ хоорондын зайг хавтан дээр тэмдэглэнэ.



Нэг бөөрөнхий хавтан дээр 4 шруп ашиглан хавтангуудаа тогтооно.



Хавтангуудыг тоосго өрөх байдлаар тэгш бусаар байрлуулна уу. Яг тэгш байх нь даац сул хэсэг гаргах эрсдэлтэй.



Хавтангуудын заадсыг гипсэн шаваас эсвэл туузаар холбоно.



Ханын хавтан суурилуулахдаа шалан дээр тулгахгүй байх. Тэлэлтийн зай ойролцоогоор 10 мм үлдээсэн байна.



Хаалганы эргэн тойронд ажиллахдаа хавтангуудыг шилжүүлэхээ санаарай.



## М-SYSTEM 3G БАГЛАА БООДОЛД БАГТАХ ЗҮЙЛС

1. Суурилуулах тавцан – 21 ширхэг
2. Бэхэлгээний шруп M8/Ø6.5, 8.8 ангилал, универсал\* – 21 ширхэг
3. L 50 Ø10 мм ВХ дюбель (гадаад диаметр 10 мм, урт L = 50 мм) – 21 ширхэг
4. Гипсэн хавтангийн шруп 3.5 x 25 – 84 ширхэг



# ХОЛБОО БАРИХ

☎ +976 99109179  
+976 88299789  
+976 80112537

📍 100 айл, Содон  
худалдааны төв, 1 давхар

